



## ГЭР ХОРООЛЛЫН АЙЛ ӨРХҮҮДИЙН ГАЛ ТҮЙМРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ НЭГДСЭН АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### Нэг. Зорилго

1.1 Галын аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах, улсын хэмжээнд гарч буй гал түймрийн тоо хохирлыг бууруулах, гэр хорооллын айл өрхүүдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар таниулах, олон нийтэд өргөн хүрээтэй сурталчлахад чиглэгдэнэ.

### Хоёр. Хугацаа, хамрах хүрээ

2.1. Гэр хорооллын айл өрхүүдийн галын аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний I үе шатыг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 04 дүгээр сарын 30, II үе шатыг 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.

2.2. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны гэр хорооллын айл өрхүүд хамрагдана.

### Гурав. Зохион байгуулалт

3.1. Бүс, орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлыг удирдамжийг боловсруулан, аймгийн Засаг даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна.

3.2. Гэр хорооллын айл өрхүүдэд галын аюулгүй байдлын үзлэг шалгалтыг явуулахдаа аймаг, нийслэлийн Засаг даргын ажлын алба, мэргэжлийн байгууллагууд, Улаан загалмайн дунд шатны хорооны сайн дурын идэвхтнүүдийг томилон ажиллуулна.

3.3. Нэгдсэн арга хэмжээний талаар мэдээлэл, зөвлөмж, зааварчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, байгууллагын цахим хуудсанд байршуулж, олон нийтийн сүлжээгээр сурталчилна.

3.4. Монгол Улсын Статистикийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй гэр хорооллын айл өрхийн 40-өөс доошгүй хувьд нь нэгдсэн арга хэмжээний хүрээнд ухуулга, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, илэрсэн зөрчлийг арилгуулна.

3.5. Баг, хорооны Засаг даргын ажлын алба айл, өрхийг үнс нурмаа ил задгүй асгахгүй байх талаар үүрэг даалгавар өгч, хяналт тавина.

3.6. Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороонд 4-өөс доошгүй удаа өдөрлөгийн арга хэмжээ зохион байгуулж, иргэд, олон нийтийг өргөнөөр хамруулна.

3.7. Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг хорооны Засаг даргын Тамгын газартай хамтран гэр хорооллын айл өрхүүдийн зам, гарц, галын автомашин нэвтрэх, чөлөөтэй зорчих байдлыг нэмэгдүүлэх арга хэмжээ авна.

3.8. Объектын гал түймрийн аюулаас сургалтад төрийн болон нутгийн захиргааны байгууллага, сургууль, цэцэрлэгийн багш, ажилтан, албан хаагчдын 40-өөс доошгүй хувийг хамруулна.

3.9. Сум, дүүрэг, баг, хорооны иргэдэд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг үе шаттайгаар зохион байгуулна.

3.10. Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газраас удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжлийн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллах.

#### **Дөрөв. Нэгдсэн арга хэмжээний үр дүн, зардал**

4.1. Төв, орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан арга хэмжээний I үе шатны тайланг 2024 оны 05 дугаар сарын 06, II үе шатны тайланг 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Урьдчилан сэргийлэх газарт [arunaanema@gmail.com](mailto:arunaanema@gmail.com) цахим хаягаар баталгаажсан тайлан, шалгуур үзүүлэлтийн хүснэгтийн хамт сканердан (файлаар, зурган тайлан) ирүүлнэ.

4.2. Улсын хэмжээнд зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээний тайланг Урьдчилан сэргийлэх газар нэгтгэн, Онцгой байдлын ерөнхий газрын даргад I үе шатыг 2024 оны 05 дугаар сарын 15, II үе шатыг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус танилцуулна. Тайлангийн хувийг Монгол Улсын Шадар сайдын ажлын албанд хүргүүлнэ.

4.3. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардлыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.1, 31.1.3-т заасны дагуу шийдвэрлүүлэх, түүнчлэн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлийн үйл ажиллагааны зардал болон төсөл хөтөлбөр, олон улсын байгууллагаас санхүүжүүлнэ.